

Дипломатч байсан арван жилээ эргэн харахад оромдож байсангүй, осолдож эндсэн нь ч бага. Баяжиж хөлжих гэж шунасангүй. Зусардаж зулгаа элээсэнгүй, дарсан ч дардаггүй, булсан ч бултайх ажигтай, сурлагын дэвтэр өвөртлөөгүй хэр нь сураар боолгох сул амьтан байсангүй. Дипломатчийн зиндаанд нүүрээ улайлгаагүй авсандаа бардам байна. Эздийнхээ чихийг халууцуулж үзсэнгүй, харин ч санаачилгатай, мэдээлэл сайтай, шуурхай ажигладаг, үүрэг даалгаврыг цагт нь гүйцэд биелүүлдэг, зорьсондоо хурдэг гэсэн үнэлэлт дүгнэлтийг хүртэж ирсэн минь гадаад харилцаанаас надад өгсөн шагнал юм. Насны наран баруунаа хэвийж, цагаан үс хуучирсны тэмдэг болсон цаг үед нэгэн удаа өөрийнхөө тухай дагд байсан зүйлийг ил гаргаад тэмдэглэсэн нь энэ буюу. Дахиад би өөрөө ч, өөр хүн миний тухай бичихгүй биз.

П.Дармаа
Түшээ

ДУРСАМЖ ЯРИА

Гадаад харилцааны яамны ажилтан Р.Янжмаа ахмад Дипломатч П.Дармаатай уулзаж дурсамж яриаг нь тэмдэглэсэн юм.

Р.Янжмаа: Та хэдэн оноос Дипломат алба хашиж эхэлсэн бэ?

П.Дармаа: Би ЗХУ-д (хуучин нэрээр) Дорно дахины судлалын Институтийн тусгай тасатг сурагцаж, 1941 онд дүүргэж ирээд Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга байсан ч, Сүрэнжавын нарийн бичгийн даргаар томилогдон 6 сар ажиллаж байтал түүнийг МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн даргаар томилж оронд нь Сангийн Яаманд нэгдүгээр орлогч сайдаар ажиллаж байсан С.Лувсанг томиллоо. Ингээд С.Лувсантай цуг ажиллаад 6 сар болж байтал буюу 1942 оны намрын үеэр нэг өдөр Лувсан гуай намайг ерөөндөө дуудаж "Чамайг наадмын үеэр нэг өдөр Лувсан гуай намайг ерөөндөө дуудаж "Чамайг албан ажлын шаардлагаар ГЯЯ-ны Өрнөд хэлтэст ажиллуулахаар болсон, чи наадмаас хойш тийшээ оч" гэдэг юм байна. Ингээд ГЯЯ-ны Өрнөд хэлтсийн даргаар томилогдов оо. ГЯЯ гол төлөв виз паспортын л асуудал хариуцдаг, бодлогын чанартай асуудлыг ерөнхий сайд л шүүхэд байлаа. Юу сайндаа 1945 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч бүрх, тэсийг манай улсад ирэхийг бид мэдэхгүй, нэг л өдөр дагалдаж дээд тэ, хүмүүсийг нь хооллуулах даалгавар аван түүнийг биелүүлэх даан явуу, тинаж байх вэ дээ.

Эзний үүрэг, энд намайг очиход ГЯЯ долоохон орон тоотой, засгийн газарт

З-өөрөө эзэлдэг байлаа. Маршал Чойбалсан ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд байлаа. Намын Төв Хороонд зөвлөх Приходов, бас засгийн зөвлөх Цапкин гээд ажиллаж байлаа шүү дээ. ГЯЯ гэдэг маань шүүдэн, нууц, шифр, аж ахуй, виз, паспортын л ажил эрхэлдэг байлаа. Манай Өрнөд хэлтэс гэж юу байх вэ дээ, ганц л би Бүх юм хариуцна, түүний эрхлэгч, Дипломат шуудан, гэрээ эрх, виз, паспорт гээд л... Асуулт: Гэрээ эрх гэж бүх гэрээ хэлэлцээрийг хариуцан боловсруулж байгуулдаг байсан хэрэг үү?

Хариулт: Үгүй, үгүй. Нэг авдарт 1921 оноос хойш байгуулсан гэрээ хэлэлцээрийг данслаг дагалдахыг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл түүний эрхлэгч, түүнээс биш бид түүнийг байгуулдаггүй байсан юм. Мөн Түвдтэй байгуулсан гэрээ бас байдаг байлаа.

Асуулт: Өрнөд хэлтэс маань чухам юу хийж байв аа?

Хариулт: Хоёрдугаар дайны үед ЗХУ-д явуулах бэлгийн зүйлийг оруулах, дайны явцын тухай ард олонд ухуулан таниулах л үүрэгтэй байсан. Бас фронтод бэлэг хүргэхээр явах хүмүүсийн паспортыг бичиж, ЗХУ-ын ЭСЯ-нд биеэрээ хүргэн өгч виз авдаг маш их ажилтай байлаа.

Асуулт: ЗХУ-ын тухай судалгаа хийж, харилцаа хөгжүүлэх талаар санал дэвшүүлж байв уу?

Хариулт: Тийм судалгаа мудалгаа гэж байгаагүй. Гол нь ЗХУ-ын төлөөлөгч байлаа шүү дээ. Манайх ч мөн адил представитель (төлөөлөгч)-тэй байсан юм. Гэхдээ гол асуудлыг Төв Хороо, маршал боловсруулдаг, тэд л шийдвэрлэдэг байлаа.

Асуулт: Бичиг хэргээаж зохион байгуулж байсан юм бэ?

Хариулт: Бичгийн эхийг бид боловсруулаад Намсрай сайдаа оруулж, Тэгээд цохилтаад маршалд өгнө.

Асуулт: Ямар хэлээр бичиг баримтаа үйлддэг байсан бэ?

Хариулт: Монголоороо бичнэ. Харин маршалын дэргэд Аюузана гэдэг сүрхий сайн орчуулагч байсан юм. Авгай нь Цэрмаа гэдэг юм. Одоо өөд болчихсон байх аа. Аюузана бүх бичиг баримтыг оруулж, нөгөө зөвлөх, сургагчид танилцуулдаг байсан байх.

Асуулт: 1921 онд ГЯЯ шинээр байгуулагдахдаа 20-иод орон байсан байсан юм байна лээ. Тэгэхлээр яагаад 1940-өөд онд тийм олон тоотой байсан юм бол?

Хариулт: Тийм ээ, тэр үед нэлээн том сүрхий яам байсан юм байсан. Яагаад сүүлд нь тийм их цөөлснийг мэдэхгүй. Хэрэгцээ бага болж л дээ.

Асуулт: Ингээд таныг 1942 онд ГЯЯ-нд ирэхэд Дипломат ажилтан байсан гэж 4 хүн байсан байх нь ээ.

Хариулт: Үгүй, 7 хүн байсан юм. Зохион байгуулалтын хувьд орлогч сайдтай, тэр нь Намсрай, 2 хэлтэстэй, өрнөд, дорнод гэж Өрнөд хэлтсийн дарга нь би, нэг жолооч, нэг бичиг хэрэг, нэг нь юу билээ дээ.

Асуулт: Мөнгөний нярав уу?

Хариулт: Үгүй тэр чинь засгийн газартай хамт байсан юм. Аа тийм нэг бичээч, ингээд бид ердөө 7-уул байлаа.

Асуулт: Засгийн газартай хамт гэдэг чинь юу гэсэн үг вэ?

Хариулт: Засгийн газартай хамт гэдэг чинь санхүү нь хамт, мөнгө зөнгө авах нь хамт, аж ахуй нь бас хамт байсан гэсэн үг.

Асуулт: Дорнод хэлтсийн даргаар хэн байлаа тэр үед?

Хариулт: Баяндүүрэнгийн Сэрээтэр.

Асуулт: Хятад хэлтэй хүн байсан уу?

Хариулт: Хятад хэл мэдэхгүй. Засгийн газарт хэрэг эрхлэх газрын орлогч даргаар ажиллаж байгаад бас л ГЯ-нд боловсон хүчин ховор учраас над шиг томилогдож очсон хүн.

Асуулт: 1940-өөд оноос шинэ бичигт улс давар орлоо. Тэр үед шинэ бичиг сурах гэж ядардаг байсан уу?

Хариулт: ГЯ-нд ажиллагсад бидэнд Цэрэндүлам гэдэг балш шинэ бичиг заадаг. Заалгаж л байсан нэг их ядраагүй.

Асуулт: Чойбалсан гуайг шинэ бичиг мэддэггүй байсан гэж ярих юм, тэр үнэн үү?

Хариулт: Яаж мэдэх юм бэ. Шинэ бичиг мэддэггүй байсан. Зөвхөн хуучин л бичиг мэднэ.

Асуулт: Оросоор сайн ярьж бичдэг хүн байсан уу?

Хариулт: Үгүй, оросоор бичдэггүй, зөвхөн ярьдаг л хүн байсан. Асуулт: Намсрай нь тэгвэл бичгийн хүн байжээ дээ?

Хариулт: Орлогч сайд Намсрай ч мөн адил. Намсрай бичгийн хүн ч байгаагүй. Оросоор сайн ярьдаг л хүн байсан юм. Оросоос зэвсэг авч байхад Намсрай гуай тэр зэвсгийг ачуулж явж байсан хүн шиг байдаг юм.

Асуулт: Зөвлөлтөөс нааш нь зэвсэг ачуулж байсан хэрэг үү?

Хариулт: Тийм ээ, манайд чинь оросын цэрэг гэж байлаа шүү. Тэдний зэвсгийг Оросоос ачуулдаг цэргийн хүн байсан юм. Тиймээс ярианы орос хэлд сайн хүн байсан. Тэр чинь др. Сэр Одын аав юм шүү дээ. Тэднийх 5 хүүхэдтэй байсан юм. Одоо ганц нь л үлдсэн байгаа байх.

Асуулт: 1940-өөд онд Улаанбаатарт ЗХУ-аас гадна Тува улсын ЭСЯ ажиллаж байсан. Тэдэнтэй ямар харилцаатай байсан бэ? Тувагийн ЭСЯ манайд хаах нь байсан бэ?

Хариулт: Цогт Бадмаевын байшин буюу Зүүн Сэлбийн зүүн эрэгт, энэгийн Сүхбаатарын музей байгаа тэр байшинд байсан юм. Тува нэгтэй харьцахад тун гайгүй ээ, гэхдээ хааяа заримдаа түвэгт үзүүлдэг л байсан. Тэднийг ирэхээр бид хүлээж аваад нэг зочид буудалд оруулна. Гэтэл тэд хэдийнээ ЭСЯ-н дээрээ очоод хоночихдог юм шүү байлаа. Бас тувачуудыг галт тэргээр явуулах гэхэд ер яваагүй, заавал онгоцоор явна гэж зүтгэх гэх мэтийн аар саар юм гардаг л байсан.

Асуулт: Тувагийн ЭСЯ чухам хэдэн онд татан буугдсан юм бэ?

Хариулт: Ер нь Тува улс ганц манайд л ЭСЯ-тай байлаа шүү дээ. 1944 онд Тува ЗХУ-д нэгдээд автономит муж нь болсон, тэр үед ЭСЯ нь татан буугдсан юм.

Асуулт: Тэр үед дипломат ёслолын арга хэмжээ их зохион байгуулдаг байсан уу?

Хариулт: Зохион байгуулна аа. Одоогийн Нацагдоржийн хөшөө байгаа тэр хавьцаа засгийн газрын арга хэмжээ зохион байгуулдаг байшин байсан юм. Тэнд л зохион байгуулдаг байсан даа.

Асуулт: Чухам ямар арга хэмжээ зохион байгуулдаг байсан бэ?

Хариулт: Голдуу л суугаа зоог зохион байгуулдаг байлаа. Жишээлбэл Тувагийн элчин сайд Очир гэдэг хүнийг нутаг буцахад нь Намсрай гуай, Сэрээтэр гуай бид 3-уулаа дээрээс нь бас ЗХУ-ын ЭСЯ-ны Баранов ингээд 5-уулаа хоол иддэг юм байна. Тэр үеэр 20 шил шампанск дарс уусан байж билээ. Та бод л доо 20 шил шампанск шүү. Өөр архи байгаагүй. Тэгэхэд Намсрай гуай жаахан согтсон, Баранов ердөө согтоогүй. Би ямар уух биш дээ. Сэрээтэр гуай уухгүй.

Тэгсэн хэрнээ яагаад 20 шил болсон юм бүү мэд ямар ч л гэсэн 20 шил шампанск уусан байгаа юм даа. Түүний тооцоог нь би хийсэн болохоороо тодорхой санаж байна. Хөгийн юм шүү.

Асуулт: Тэр үед Улаанбаатарт ЗХУ-ын ЭСЯ байлаа. Тэдэнд хариулж ГЯ-наас арга хэмжээ зохион байгуулдаг байв уу?

Хариулт: Нэг их арга хэмжээ зохиож байгаагүй.

Асуулт: За ингээд дайн дууслаа. Дайн дуусахын өмнө 1945 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч Уэльс манайд ирсэн. Түүнийг угтаж авах ажлыг зохион байгуулахад хэрхэн оролцсон бэ?

Хариулт: Үгүй ГЯ тэр үед чинь тийм үүрэгтэй байгаагүй шүү дээ. Дотоод яам гэдэг чинь тагнуулын байгууллага байхгүй юу. Уэльс гэдэг чинь тагнуул, дайсан байлаа шүү дээ. Тийм учраас Дотоод Яам гэдэг ажлыг нь мэддэг байсан. Харин бид нар болохоор аар саархан ажлыг нь амжуулж явлаа. Жишээ нь Нүхтэд нэг модон байшин байлаа. Тэр модон байшинд Уэльсийг хүлээн авч байсан юм. Тэнд ор

дэр бэлтгүүлэх ажлаар ганц нэг удаа очсон.

Асуулт: Та яриа хэлэлцээнд нь сууж байв уу?

Хариулт: Үгүй, яриа хэлэлцээ гэж нэг их юм болоогүй.

Асуулт: Хотоор явахад нь дагалдаж байв уу.

Хариулт: Үгүй, дагаж явж байгаагүй. Нэг англи хэлтэй хүн датаж явж байсан.

Асуулт: Англи хэлтэй ямар хүн датаж явж байсан юм бэ?

Хариулт: Дотоод яамнаас л хүн гаргасан юм даг. Дотоод яамнаас бүх ажлыг зохион байгуулсан. Дамба дарга үйлчилж байсан. Харин бид нар "Учиртай гурван толгой"-г бөмбөгөр театрт үзэхэд нь маршал Чойбалсангийн даалгавраар бүгдээрээ монгол дээл, бүрх малгайтай очиж байсан. Тэрнээс өөр юманд оролцоогүй. Дамба дарга үйлчилээд, Нүхтэд Дотоод яамны комиссарууд л дагаж явж байсан юм даг.

Асуулт: Уэльсийг Латтимор гуай дагалдаж ирсэн шүү дээ.

Хариулт: Тийм, Латтимор дагалдаж ирсэн. Тэгээд Латтимор л энэ айлчлалын тухай дэлхий дахинд ярьчихгүй юу даа. Тэр үед чинь манай Бямбын Ринчин гуай хааны музейд орчуулагч тайлбарлагч байсан юм.

Асуулт: Ямар хэлээр орчуулж байсан юм бол?

Хариулт: Англи хэлээр. Англиар л ярина шүү дээ. Тэгэхээр Уэльс Ринчин гуайгаас "Та яасан сайн хэлтэй юм бэ? Хаана, яаж сурсан юм бэ?" гэж асуужээ. Ринчин гуай "За би өөрөө л сурсан ухаантай даа" гэж хариулсан гэнэ лээ.

Асуулт: За тэгвэл тэр үед чинь ГЯН-ны үүрэг маш бага байжээ дээ?

Хариулт: Тийм ээ, үнэхээр ГЯН-ны үүрэг маш бага. Дотоод яамны үүрэг маш их, ер нь голдуу гаднаас ирсэн хүмүүсийг чинь тагнуул гэж үздэг байлаа шүү дээ. Тийм учраас Дотоод яам л хариуцдаг байлаа. Тэгээд ч бид тэднээс их айна шүү дээ.

Асуулт: Тэгвэл ГЯН-нд судалгаа хийдэг байсан уу?

Хариулт: Үгүй, тийм юм огт байхгүй.

Асуулт: 1945 онд манайд болсон бүх нийтийн санал асуултыг зохион байгуулахад ГЯН хэрхэн оролцсон бэ?

Хариулт: Санал асуултыг ажиглахаар Хятадаас Дотоод яамны орлогч сайд Ли Фажан (цаашид Ли хэмээн товчлов) тэргүүтэй төлөөлөгчид ирсэн. Дорнод хэлтсийн эрхлэгч Сэрээтэр датаж үйлчилсэн. Мөн "Правда", "Известия" сонинь сурвалжлагчид ирсэн. ГЯН-н дээр ярилцлага болсон. Тэгэхэд ГЯН Батшийн сургуулийн зүүнтээ байлаа. Бид цай зөөж давхмад л байлаа. Орчуулагч нь Лувсандондовринчин бил үү, хэн билээ дээ нэг их урт нэртэй

Завсрамонгол хүн байсан. Нэг урт ширээний толгойд маршал Чойбалсан, Ли нар сууж байсан юм. Тэдний дэргэд хоёр орчуулагч нь. Манайхаас Ринчинсоном гуай орчуулж байлаа. Ли-гийн ярьсны дараа орчуулагч нь Ринчинсоном гуайд хандаад "Та хэлмэрчил дээ" гээд байдаг. Ринчинсоном гуай Ли-гийн хэлснийг маршалд хэлмэрчилнэ. Бас маршалын хэлснийг орчуулна. Нөгөө хятад орчуулагч нь бас чадахгүй. Ер нь тэдний орчуулагч монгол хэл муутай хүн байсан шиг санагддаг. Тэр нь манайд их сайн талтай болсон. Өөрийн хүн санаагаа зөв гаргаж орчуулж байгаа учраас манайд их сайн талтай болсон.

Асуулт: Тэр үед манай ГЯН-нд ЗХУ-ын сургагч, зөвлөх гэж байсан уу?

Хариулт: Үгүй, үгүй байгаагүй.

Асуулт: Засгийн газарт л байсан хэрэг үү.

Хариулт: Тийм, Засгийн газарт 2 зөвлөх байсан.

Асуулт: Тэр засгийн газрын зөвлөхүүдээс та нар юм асуудаг байв уу?

Хариулт: Үгүй. Ямар юм асуух вэ? Юу ч ярихгүй. Чойбалсан гуай 2 зөвлөхтэй. НТХ-ны зөвлөх Сидоров гэж байсан юм.

Асуулт: Бичиг баримт боловсруулаад дараа нь зөвлөлтийнхөнд үзүүлж асуудаг байсан шүү дээ. Тэгж асуудаг байсан уу?

Хариулт: Үгүй. Тийм юм байхгүй. Би мэдэхгүй байна.

Асуулт: Бичиг баримт боловсруулаад л шууд явуулчихдаг байсан юм уу?

Хариулт: Бичиг баримтыг боловсруулаад орчуулуулахаар Аюузраанаевт өгнө. Гарч ирэхээр нь бид нот болгож бичээд дахин нэг тгнүүлээд, орос дээрхийг нь дахин дахин зөв бурууг нь нягталж үзээд (орос дээрхийг бид нэг юм уншина л даа) тэгээд л Чойбалсан гуайгаар нэг үзүүлээд л явуулдаг байсан юм.

Асуулт: Уэльс яагаад манай улсад ирэх болсон юм бэ?

Хариулт: Бүү мэд. Гэв гэнэтхэн, нэг үдээс хойш л Америкийн дэд ерөнхийлөгч манайд өөрийн онгоцоор ирэх боллоо гэж манай орлогч сайд бидэнд хэлсэн. Намсрай гуай дээшээ дуудалдаад л явсан, эрэгж ирээд бидэнд тийм мэдээ дуулгаж, орон байрыг нь бэлтгэх үүрэг өгсөн.

Асуулт: Та тэгэхэд Өрнөд хэлтсийн дарга байсан. Уэльсийн ирэх асуудлыг туруулж мэдэх ёстой байсан бус уу?

Хариулт: Уг нь мэдэх л ёстой.

Асуулт: Тэгээд асуудлыг Дотоод яамнаас оруулсан хэрэг үү.

Хариулт: Тийм л хэрэг байх. Бидэнд ямар шифр харилцаа байх бил, тэднээр л дамжиж асуудал шийдэгдсэн байх.

Асуулт: Дайн дууссанаас хойш манай гадаад харилцаа хэрхэн хөгжиж байв аа?

Хариулт: ЗХУ-д сууж байсан бүрэн эрх барих төлөөлөгч маань Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд боллоо. ГЯД өргөжлөө. Дорнод хэлтэс, Европ хэлтэс бий боллоо. ГЯД-ны зөвлөх гэж орон тоо бий боллоо.

Асуулт: ГЯД-ны зөвлөхөөр хэн ажиллаж байв аа.

Хариулт: Норовсамбуу гэж байсан юм. Маршал Чойбалсан ГЯД-ны сайд байхаа больж, Лхамсүрэн сайд боллоо (Нянтайсүрэнгийн) Эрхүүд Цэдэнбалтай хамт рабфакт сурч байсан юм. Хэрэг эрхлэх газар, нарийн бичгийн дарга нарын газартай боллоо. Ингээд нэлээд томорч өргөжлөө.

Асуулт: Тийнхүү өргөжихөд гадаад хэл мэддэг хүмүүс ГЯД-нд ирсэн үү?

Хариулт: Хэлтэй хүмүүс ерөөс ирээгүй. Дандаа Дотоод яамнаас хүмүүс ирсэн юм.

Асуулт: За тэгвэл Дотоод яам маань гадаад яам болж, тэр үеэс "Гаднаа Гадаад яам, дотроо Дотоод яам" гэдэг үг гарсан байх нь ээ дээ?

Хариулт: Тийм ээ. Яг л үндсэндээ тийм, яг л хуучнаараа байхгүй юу даа. Дотоод яамнаас Санжматав, Цэрэндорж гээд зөндөө хүмүүс ирсэн юм даг.

Асуулт: За ингээд 1949 он болж, Хятад улс байгуулагдлаа. Ингээд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтож ЭСЯ-даа харилцан нээн ажиллуулах болсон биз дээ.

Хариулт: Тэрнээс чинь өмнө Чан Чунь хэлэлцээ гэж болсон юм. Чан Чунь хэлэлцээнд Сүрэнжав тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Тэгэхэд Лхамсүрэн явсан, гэхдээ сайд болгоогүй байсан юм. Орчуулагчаар нь Бат-Очир, Ринчинсоном хоёр явсан. Бат-Очир бол улс төрийн талаар айхавтар сүрхий мэдлэгтэй хүн байж билээ. Чан Чунд хэлэлцээ хийгээд, дараа нь Хятадын ГЯД-ныхан манайхныг хүлээж авсан юм гэдэг. Ер нь Чан Чунь хэлэлцээ манайд их сайн талтай болсон. Ямар ч л гэсэн муу юм болгоогүй юм даг.

Лиг-ийн ирдэг бол Сталин, Ялгын хэлэлцээтэй холбоотой. Ялтад болсон 3 гүрний хэлэлцээн дээр Сталин шахаж байж хэрэв монголын ард түмэн саналаа өгөх юм бол ЕНМАУ-ыг тухайн үеийнх нь байгаагаар хэвээр байлгана гэж бичсэн байдаг шүү дээ. Түүнтэй холбоотойгоор Чан Чунь хэлэлцээ явагдсан юм.

Асуулт: За тэгээд ардын ардчилсан гэдэг улсууд бий боллоо. Түүнтэй холбогдуулан танай хэлтсийн ажил үүрэг хэрхэн яаж нэмэгдсэн бэ?

Хариулт: Манай өрнөд хэлтэс маань өргөжиж, даргаар нь Дотоод яамнаас Гомбосүрэн гэдэг хүн ирлээ. Би ахлах референт болов. Би ч нэг ээ, ажлаа мэдэх юм болохоор хийгээд л нөгөө Гомбосүрэн дэргэдээ танилцуулна.

Асуулт: 1946 онд ЗХУ-тай найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулагдсан. Уг гэрээг байгуулахад та оролцож байсан уу?

Хариулт: Үгүй, би оролцож байгаагүй.

Тэр гэрээний чинь эхийг оросууд боловсруулж ирүүлэхээр нь орчуулчихдаг байсан. Ер нь тийм маягаар явж ирсэн юм шүү дээ гүүхээ.

Асуулт: Төслийн орчуулгад та нар санал онолоо хэлдэг байсан гэж үү.

Хариулт: Тийм л дээ. Ер нь тэр гэрээг байгуулахад ЗХУ-д суугаа манай ЭСЯ л голлох үүрэгтэй оролцсон юм.

Асуулт: Тэр үед өглөөний 9 цагаас оройны 10-11 цаг хүртэл ажиллаж байсан гэж хуучуул ярьдаг шүү дээ. Та ч мөн тэрх ажиллаж байсан уу?

Хариулт: Тиймээ.

Асуулт: Тийм олон виз, паспортын асуудал гардаг байсан уу?

Хариулт: Гадаадад явах бүх л хүний виз паспортын асуудлыг эрхэлдэг байсан юм. Би бүх паспортаа бичээд биеэр ЗХУ-ын ЭСЯ-нд хүргэж виз авдаг байсан юм.

Асуулт: Паспортаа хаана хэвлүүлдэг байсан юм бэ?

Хариулт: 1946 онд ГЯД-нд консулын хэлтэс байгуулагдсан. Консулын дүрэм боловсруулсан. Паспортын загварыг шинэчилж ОХУ-д хэвлүүлсэн. Консулын дүрмийг анх генерал Цэдэн-Иш боловсруулаад Сандаг (др. Ш. Сандаг) орчуулсан юмдаг.

1945 оныг дуусгал ГЯД маань дайны үеийн байдлаар ажиллаж, тусламжийн зүйл цуглуулах, дайны явцын талаар ухуулах зэрэг ажиллагаа явуулж байлаа. 1946 онд ГЯД-нд өөрчлөлт хийснээр ажил хэлээд хөнгөрсөн юм. Над дээр байсан гэрээ эрх, консул, бичиг зэргийн ажлыг өөр хүмүүст шилжүүлсэн.

Асуулт: 1946 онд манай улс мэргэжлийн дипломатчдаа багтахээр ЗХУ-д анх явуулсан гэдэг. Тэгэхэд та боловсон хүчин хийж байсан байх аа? Ямар шалгуураар хүмүүсээ шилж сонгож суулж байсан бэ?

Хариулт: Тийм ээ. Тэр ажлыг би гардан хийсэн юм. Их сургуулиас орос хэл сайтай гайгүй хэдэн залууг сонгож ирээд Лхамсүрэнд шалгуулав. Лхамсүрэн орос хэл сайтай л даа. Дараа нь маршал Чойбалсанд танилцуулсан Маршал тэгэхэд "энэ оюутнуудад мөнгө

Битгий өг, харин эд аж ахуйн талаар тусла" гэлээ. Тэгэхэд жингийн үнээр худалдаж авсан трикометр, люкс гэдэг даавуу тавьж өгч байсан. Манай яам нэг муу автобустай. Түүгээрээ Сонгино, Хондын амралт явдаг байв. Лочин гэдэг нэг дипломатч байгаад нас барсан шүү дээ. Тэр Лочин "трикометр даавуугаа люкс даавуугаар сольж өгөөч" гэж хэлээд надад загтуулж явсан юм даа хөөрхий.

Асуулт: Жаргалсайхан гуай та хоёр нэлээд удаан жил хамт ажиллаж байсан хоёр. Сонин тохиолдол юу байна?

Хариулт: Юу байх вэ дээ. Бид хоёр бие биенээ сайн мэддэг. Эндээс Намсрай гуай бидний гарын үсэгтэй бичиг явдаг байв. Москва дахь ЭСЯ-нд Жаргалсайхан ажиллаж байсан бөгөөд бичиг хэргээ эрхэлдэг учир эндээс явуулсан шууданг хүлээж авдаг, бас ЭСЯ-ныхаа шууданг эрхлэн явуулдаг байсан юм.

Асуулт: Та Жаргалсайхан сайдыг бангадаж байв уу?

Хариулт: Бангадах гэж юу байх вэ дээ. Бангадахаар ч юм хийхгүй. Хэрэг гарвал Намсрай гуайтай элбээд юм бичнэ л дээ. Гэхдээ нэг их сүйд болох юм байхгүй. Самбуу гуай, Жаргалсайхан хоёр чинь их сүрхий хүмүүс байсан юм. Самбуу гуай Москвад (элчин сайдаар) 10 жил ажиллаад 1946 онд ирэхэд оронд нь Ядамжав сайд очсон юм. Асуулт: Самбуу гуайг солих хүн байгаагүй юм байх даа. Манай түүхийн хамгийн эгзэгтэй үе 1936-1940 онд Москвад байж дээ.

Хариулт: Самбуу гуай их сүрхий хүн байсан юм. Ядамжав ч мөн сүрхий хүн байсан.

Асуулт: За тэгээд манай улс ЭСЯ-аа Хятадад нээсэн байх аа?

Хариулт: Тийм ээ, Бээжинд ЭСЯ-аа нээж, Жаргалсайхан элчин сайдаар явлаа.

Асуулт: Энд төв аппарат өргөжиж ээ дээ.

Хариулт: Тийм ээ, Самбуу гуай Дорнод хэлтсийн даргаар, орлогчоор нь Санжмятав болов. Цэрэндорж референт, бас Дөрвөлжин энэ тэр гээд яамнаас ирсэн хүмүүс байдаг байсан.

Асуулт: Тэр үед гадаадаас Монголд ирвэ гэсэн сурвалжлагч, бас бус хүмүүс байсан юм байна шүү дээ.

Хариулт: За мэдэхгүй юм. Миний үед л дайралдаагүй юм байна. Тийм асуудал чинь тэр үед Дотоод яаманд л харьяалагддаг байлаа шүү дээ.

Асуулт: ГЯД мэддэггүй байсан хэрэг үү?

Хариулт: Тийм ээ, ГЯД-нд бидэнд хэдхэн хавтас байдаг, түүн дотор харьяат болъё энэ тэр гэсэн цөөхөн асуудал байдаг байлаа.

Асуулт: ГЯД чухам хэдийнээс өнөөдрийнхөө өнгө авс, дүр төрхийг олсон юм бэ?

Хариулт: 1950-иад оноос хойш л жинхэнэ тусгаар тогтносон улсын ГЯД-ны төрхийг олсон юм. Түүнээс өмнө ГЯД гэхэд одоо бодоход анхдаг хүрэм байлаа шүү дээ. Өрнөд хэлтэс гэхэд ганц референт хэрнээ дарга нэртэй, баахан олон юм хариуцсан, олон төмөр албартай л хүн байсан.

Асуулт: Архив гэж байсан уу?

Хариулт: Архив гэж юу байх вэ дээ. Түрүүн хэлсэн тэр гэрээ хэлэлцээр, нот бичгийг хийсэн хэдэн авдарнаас өөр юм байгаагүй.

Асуулт: Виз, паспортын холбогдолтой бичгүүдээ яадаг байв?

Хариулт: Хэлтэстээ л хадгалдаг, өөр ийш тийш нь өгдөггүй байлаа.

Асуулт: Энэтхэг болон бусад улсуудтай харилцаа тогтоох санаачилга чухам хаанаас гарсан гэж та боддог вэ?

Хариулт: Европ хэлтэс ЗХУ-ыг хариуцдаг байлаа. Хятадтай харилцаа тогтоох санал Дорнод хэлтэстээ л гарсан байх таараа. Харин Европын бусад оронтой гэрээ хэлэлцээр байгуулахыг Европ хэлтэс ЗХУ-д суугаа ЭСЯ-аар дамжуулан санаачилсан байх. 1940-өөд оны сүүлчээр анх Чехословак, Болгар хоёртой харилцаа тогтоосон юм. Манай яаманд орчуулга хариуцсан Цэрэндондог гэж орос хэл сайн мэддэг, гадаад эдийн засгийн харилцааны сургууль төгссөн нэг хүн ирсэн юм. Орос хэлэнд сайн хүн байсан. Харин Гомбосүрэн бол одоогоор сайн ярьдаг, бичихдээ тааруу хүн байсан юм.

Тэгж явж байгаад 1950 оноос би дипломат элч болж, шуудан сургадэг боллоо. Гол нь Орос, Хятадад байгаа ЭСЯ-ндаа шуудан явдаг байв. 1951 онд бил үү АНУ Солонгос руу довтлоход Чулуун, Уламбаяр хоёртой хамт шуудан хүргэдэг байв. Тэр үед хэцүү, эндээс Бээжин ороод, Бээжинтээс Дун Бэйши руу явж Мүгдэнд очиж галт тэрэг солино. Тэндээс Хятадын сайн дурынхан явдаг байв. Тэгж байтал Солонгос (хойд) руу Хятадын сайн дурынхан явдаг байв. Тэгж байтал Бээжингийн довтолгоо ширүүсэн үед Уламбаяр бид хоёр нэг удаа шуудан хүргэхээр явлаа. Зүүн хойд Хятад очих тул бид хоёр чонон эх эмсчихсэн, нэлээд сүртэй улсууд явлаа. Замд галт тэргэнд явж байхад чонон дахнаас маань хятадын сайн дурынхан татдаг юм байна. Уламбаяр маань Дотоод яамны юм болохоор тэр талаар сургууль мэдсэн, дээрээс нь бас хятадаар ярьдаг.

Тунхуа гэдэг хотод очлоо. Уламбаяр намайг "Та байж бай Солонгосоос нэг орчуулагч ирнэ" гээд галт тэрэгний буудал руу явж байхад нэг хүн дагуулаад ирлээ. За тэгээд Тунхуагаас цааш явж илгөө. Тунхуагаас цааш явахад Ялузын гэдэг мөрөн тааралддаг юм. Ялузын бол Хятад, Солонгосын хоорондуур урсдаг том

мөрөн. Түүний цаад хөвөөнд Мекоху гэдэг хотод очлоо. Очсон чинь манай ЭСД-ныхан хүлээн авлаа. Хотын ихэнх барилта байшин сүйрчихсэн байв. Манайхны байрлаж байсан байшин нь сүйдчихсэн идэх юм олдохоо больчихсон гээд их л хэцүүхэндүү байгаагаа ярьж билээ. Элчин сайдаар Самбуу гуай байлаа. Нисэх онгоцны дайралт бөмбөгдөлтөөс хамгаалах байрны аман дээр миний авахуулсан нэг зураг бий дээ. Элчин сайд Самбуу гуай "За 13 онгоц өнгөртлөө" гэв Дараагийнхыг нь ирэхийг хүлээ гэж байтал Самбуу гуай шатраг бариад бөмбөгнөөс хоргодох газар руу орж байсан юм. Их тайван хү байсан шуу. Онгоц ирсэнгүй, нам боллоо.

Түүнээс хойш Солонгос руу шуудан дагнан хүргэдэг боллоо. Орчуулагч байхгүй, ганцаараа Бээжингээс яваад Аньдун очно. Аньдунд ЭСД-ныхан машинаар ирж авна. Нэг удаа манай ЭСД-ны машин ирсэнгүй. "Унгарын ЭСД-ны жолооч очно, тэр аваад ирнэ гэж хэлүүлсэн байсан юм. Тэгээд хүлээж байтал унгарын жолооч нэг өндөр ачааны машинтай ирлээ. Дээр нь баахан шохой энэ тэр аччихса байлаа. Нөгөөдөхтэй нь суугаад явлаа. Тэтгэл замд бөмбөгдөөс салдаггүй. Харайж буугаад л, эргэж суугаад л явлаа. Мөн ч залуу бай дээ. Тэрг явсаар нэг юм хүрлээ.

Ер нь олон удаа тиймэрхүүгээр явж билээ. Дараа нь Солонгос ЭСД-нд аж ахуйн даргаар явлаа. Аж ахуйн дарга гэдэг чинь ЭСД-ны бүх юмыг олж бэлтгэдэг байлаа. Дайны үе учраас юм ховор, голдуу хятадын Аньдун хотоос хүнсээ базаадаг байв.

Улс тунхагласны 30 жилийн ойгоор элчин сайд Равдан гуай намаа дуудаад "За Аньдунгаас 30 тахиа, нэг гахай бас бус юм олж ир" гэдэг даалгавар өгдөг юм байна. Би тэр үед дайнтай учраас голдуу шөнө явна. Нэг сайн солонгос жолооч байсан юм. Аньдун хүртэл 270 км, нь ч тайгүй л дээ. Давхиад хүрээд очлоо. За 30 тахиа, 90 кило-ын нэг гахай аваад машин дээрээ ачаад л хөдөллөө. Өдөр явлаа. Бөмбөгдөх нь овоо тайгүй байна. Тэр үед чинь хятадууд солонгосчуудад ноёрхуу байсан чинь араас буугаад байна. Жолооч маань "зогсох уу, яах вэ байсан чинь хэрэггүй яваад бай" гэлээ. Би гэдэг хүн чинь нэг их цага гэхээр нь "хэрэггүй яваад бай" гэлээ. Би гэдэг хүн чинь нэг их цага өмдтэй, калибрын ТТ хажуудаа зүүчихсэн амьтан.

"Тэгсэн чинь араас буугаад, хөөгөөд л байна. Яваад л байлаа. Тэг байтал нөгөөдүүл чинь биднийг гүйцээд урд гараад эргэж зогсчихлоо. Тэгсэн чинь эз бүү үзэгд, нөгөө машин дотроос генерал хувцастай хүн буугаад ирж яваа харалдаа. Би ч буугаад өмнөөс очоод л "Что такое?, Стрелять что ли?" гээд гараа буу руугаа

гаруулаа. Тэгсэн чинь нөгөөдөх чинь "Извините пожалуйста" гэж гэгээд машиндаа суугаад эргээд алта болдог юм байна. Тэгээд машин руугаа очсон чинь жолооч маань элэг нь хатгалаа хөхөрч байна. Дав гэсэн чинь, та генерал айлгаад явуулчихлаа гээд л унаж тустлаа. Дармаа гуай генерал айлгасан" гэдэг яриа тараачихжээ. Тэгээд бөөн болж билээ. За тэгээд олон л удаа шуудан хүргэж, бууж, зугтааж, хэллөж явсныг хэлж барах вэ.

Өө тийм. Нэг удаа Чулуунтай хамт Солонгос руу шуудан хүргээд буцаж явлаа. Манай ЭСД Марам гэдэг тосгонд байдал байлаа. Мармаас баруун тийш Барын тосгон гэж байдаг. Барын тосгон явтал нэг бөмбөгдөгч онгоц, шуугиад орж ирдэг байна. Тэгэхлээр нь би шуудангаа аваад л урд сууж байсан Чулууныхаа руу харайж буугаад л өндөр ургасан эрдэнэ шишийн талбай руу очоод хэвтчихлээ. Нөгөө Чулуун маань санжийгаад хойноос бууж Хувцаа гүвж яваа харагдав. Ер нь их намбай, цэмцгэр хүн байсан юм. Бөмбөгдөх гайгүй болж, машин руугаа очлоо. Тэтгэл нөгөө түүн маань "Дармаа чи насан заваан юм бэ? Хүний толгой дээгүүр хайтгаад гэхлээр "Чиний толгой дээгүүр харайх ч яамай. Хүний амьсгалтай байсан даа. Амь, шуудан хоёроо л хамгаалах хэрэгтэй дээ" гэж тар түр хийж явлаа шуу.

Ингээд би шуудан хүргэж байснаа больчихлоо. Ёслолын хэлтэст хэлтэс хийж эхэллээ. Ёслолын хэлтсийн даргаар Буянтын цэргэн байв.

Тэгээд 1950-иад оны суулээр жинхэнэ дипломат элчээр тогтодлоо. Ингээд Москва, Бээжин бас цаашаа явдаг болж. Энэтхэгт явдаг байлаа. Энэтхэгт шуудан хүргэхэд их хэцүү байлаа. Очоод нэг хоноод л гарахгүй бол болохгүй. Унааны гарахгүйгээс олон хоног хүлээж зардал их гаргадаг байлаа. Нэг Адилбиш гуайн авгай хүү, охинтойгоо, Хашбат, бас Ёндон гээд боллоо. Тэгсэн Ёндон "Дармаа гуайд суудал олддоггүй" гээд гэдэг юм байна. Угүй, яагаад олддоггүй билээ гээд л нэг энэтхэгтэй хоёул онгоцны буудал руу давхилаа. Очсон чинь үүдэнд зогсож байна. Энэтхэгийн цагдаа гэж нэг хачнаар үсээ ороосон байдал юм л даа. Тэр цагдааг хараад л "Үнд л нэг юм (хахууль) гэж явчихъя" гэж бодлоод Монгол, ЭСД гэж хэлээд билет хэрэгтэй газраа зангаж байж нэг ойлгуулаад ЭСД-ныхны өгсөн нэг айм том виски атгуулчихаа. Тэгээд л явчихлаа. Тэгсэн чинь ар гэрт юм яриад л байлаа, удалгүй монголын дипломат элчид очлоо л гэх аяны юм нөгөөдөх чинь ярьж байлаа. Тэр үед

чинь нэг шил виски 100 рублий байлаа.

Асуулт: 100 рублий гэдэг маань юу гэсэн үг вэ?

Хариулт: Их мөнгө лав л 5-6 ам.доллар гэсэн үг. Манай ЭСЯ-ныхан захиалж 8-хан рублийгээр шотландын виски авдаг байсан байхгүй юу даа. Тэгсэн чинь нөгөө хүн маань намайг чинь хөтлөөд л онгоцонд оруулж суулгаваа.

Тэгэхэд Хашбат, Ёндон хоёр "Энэ Дармаа гуай хэл мэдэхгүй. Бид бүх л арга чаргаа барьж хөөцөлдөөд бүтэхгүй байхад явж байгаад бүтээчихдэг байна аа" гээд гайхсан гэнэ лээ. Би ч тэгээд л яваад өгсөн. Вьетнамд шуудан хүргэж явахад хэцүү л байлаа. Бас л олон хоног болдог байсан юм.

Асуулт: Та мөн л дайны үед нь явж байл уу?

Хариулт: Тийм ээ. Бас бөмбөгдөлтийн үед АНУ, Хятад хоёр харилцан холбоотой байсан юм. Лагаад гэвэл америкийн онгоц хятадын онгоцыг бөмбөгдөдөггүй байсан юм билээ. Нэг удаа шуудан хүргээд очтол, лав л 3 хоног бардам байх боллоо. Би явна гээд л Барстай цут билет авахаар явлаа. Жолооч маань "Америкийн онгоцууд ирэх болж байна" гэдэг байлаа. Бид Улаан голыг перевозоор гараад л нисэх онгоцны буудал хүрч тасалбар авлаа. Тэгээд л онгоцонд сууж нисээд ердөө 30-хан минут болоод Нанинь гэж Хятадын хилийн хотод буухад америкийн онгоцууд Вьетнамын онгоцны буудлыг бөмбөгдлөө гэж мэдээ ирж байв. Тиймэрхүү л явж байлаа.

Асуулт: Манай ЭСЯ-ныхан таныг хүрээд очиход халамжит эцгээ ирсэн мэт утгаж авдаг байсан биз дээ.

Хариулт: Хүний мөрөөсөл болсон улс чинь хүлээгээд л сайхан авна аа. Зарим ЭСЯ-нд шуудан хүргээд 45-хан минут болоод эргээд нисэж байлаа. Шаравыг Вьетнамд байхад очоод 40-өөд минут болоод буцаж нисэж байв. Мөн Цэрэндоржийн үед бас нэг удаа Москвад нисэж очоод шуудангаа өгчихөөд цаг болоод эргэж нисэж байв.

Асуулт: Та Нью-Йорк руу шуудан хүргэж байв уу?

Хариулт: Үгүй, харин Кубад шуудан хүргэж байсан. Сансрын нисэгч Гуррачаагийн холбогдолтой материалыг хүргэж өгсөн. Тэгэхэд элчин сайд Цэнд гуай байсан.

Асуулт: Дорнод Европын орнуудаар явж байхад тань сонин Учрал тохиолдож байв уу. Түгшүүртэй зэвгүй юм тохиолдож байв уу.

Хариулт: Үгүй, их тайван байсан. Их төлөв галт тэргээр явдаг байлаа.

Асуулт: Хятадад соёлын хувьсгалын үед явж байв уу?

Хариулт: Үгүй, тэр үед би Хятад руу явж байгаагүй. Харин соёлын хувьсгал дуусч байх үед нэг явсан. Тэгэхэд Цэдэнбалын толгойг хата

аахыг энэ тэр гэсэн юм ярьж байна л гэж дуулж байсан. Харин нагтай тийм улс дайралдаагүй.

Асуулт: ГЯД маань өнөөгийн байрандаа хэдэн онд нууж орсон юм бэ?

Хариулт: 1949 оны эхээр орсон шиг санагдана.

Асуулт: ГЯД-ны өргөтгөл, өөрөөр хэлбэл тухайн үедээ ГЯД-ны эмгэлтэн нарын байр гэдгийг хэдэн онд барьсан юм бэ?

Хариулт: 1955-1956 оны үед барьсан байх.

Асуулт: Дайн эхэлж байх тэр үед МУИС баригдаж ашиглалтад орсон. Та ГЯД-ны өрнөд хэлтсийн даргын хувьд яаж оролцож байсан бэ? Нээлтэд нь оролцож байв уу?

Хариулт: Нээлтэд нь оролцоогүй. Харин МУИС-ийн тоног төхөөрөмжийг хүргэж ирсэн хэдэн орос жолоочид үйлчилж, тэднийг хөдөлүүлж, архи уулгаж, бэлэг авч өгч байсан.

Асуулт: Дайны дараа Монголд төмөр зам байгуулах тухай асуудал гарч ирсэн. ГЯД-аар хэлэлцээ яриа нь явагдсан уу?

Хариулт: Үгүй, хойгуур л яригдаад шийдвэрлэгдсэн байх. Төв хороогоор л асуудал нь яригдсан байх. Харин ГЯД-н дээр нэг том илтээн авалт болсон. Тэр хүлээн авалтад зөвлөлтийнхнийг урьж оролцуулсан.

Асуулт: Та Аварзэд гуайтай хамт ажиллаж байв уу?

Хариулт: Аварзэд чинь мэргэжлийн анхны 6 дипломатчийн нэг байв дээ.

Асуулт: Аварзэд гуай чухам ямархуу хүн байсан бэ?

Хариулт: Тун сайн, их юм мэддэг, жаахан хурц, чадалтай хүн байсан юм.

Асуулт: Хувийн гэхээр дутагдал байсан болов уу?

Хариулт: Архи хааяа амсчихна.

Асуулт: Хэдийнээс тэгэж амсчихдаг болсон юм бол?

Хариулт: Давстын хэлэлцээнээс хойш л амсчихдаг болсон байх.

Асуулт: Тувагийн хэлэлцээний явцыг та мэдэж байв уу?

Хариулт: Үгүй дээ. Тувагийн асуудал манай Дорнод хэлтэст байсан. Сэрээтэр л мэдэж байсан байх. Зураг гаргаад л, Сандаг бас би билээ дээ оролцоод, манай хилийнхэн л голлож зүргийг нь авдаг, асуудлыг боловсруулдаг байсан юм.

1963 онд Чойбалсан намайг суртлын бригадаар Увс руу явуулсан байх. Тэгэхдээ байдлыг мэдэж ир гэж явуулсан. Тэгэхэд би Давст, Бондогойг, Боршоогоор явж ирсэн. Ирээд нэг илтгэх хуудас бичээд 1946 онд ГЯД-нд нэг хачин юм болсон юм. Тэгэхэд ГЯД-нд

өөрчлөлт болсон юм. Тэр үед юм хүм, зарим бичиг цаас нэлээдийг устгахсан. Эмхэлж байгаа нь энэ гээд их тааруу муу юм хийсэн. Их юм алга болсон. Жишээ нь Тувагийн хилийн тухай нэг мундаг газрын зураг байдаг байлаа. Тэр зураг алга болсон гээд яриада байвал зөндөө л юм бий. Ингээд яриагаа өндөрлөө дөө.

Бу.Дашцэрэн

Ош бөгөөд Бүрэн эрхт элчин сайд

Ц.Дэмиддагва

Ош бөгөөд Бүрэн эрхт элчин сайд

Д.АДИЛБИШ ГУАЙН ГЭГЭЭН ДУРСГАЛД

Дашийн Адилбиш 1917 оны гуравдугаар сарын 16-нд Өвөрхангай аймгийн Төгрөг сумын нутагт төрж, бага наснаасаа сумын хоршоо, цэргийн гар үйлдвэр, монгол тээх, Улсын Бага хуралд биеийн хөдөлмөрийн ажил хийж, хөдөлмөрийн амт шимийг хүртэж, амьдралын их замаа эхэлжээ.

Хөдөлмөр хийхэд юуны өмнө эрдэм боловсрол зайлшгүй хэрэгтэй тул Д.Адилбиш Москва дахь дорно дахины дээд сургуульд орж 1942 онд төгсгөөд МАХН-ын төв алпаратад зааварлагч, хэлтсийн дарга, 1946 оноос МУЭТЗ-ийн дарга, 1950 оноос ЗХУ-д (хуучин нэрээр) ЭСЯ-ны зөвлөх, дараа нь мөн улсад болон Зүүн Европын социалист гэгдэж байсан орнуудад элчин сайд, 1956 оноос ГЯН-ны сайд, 1957 оноос Унгарт элчин сайд, 1961 оноос Намын Төв Хороо, Засгийн газрын үйлчилгээ, аж ахуйн газрын дарга, 1962 оноос Энэтхэгт элчин сайд, 1963 оноос ЭТНБХГХ-ны дарга, 1973 оноос Югославт элчин сайдын өндөр харилцаатай албыг нэр төртэй хашиж байгаад 1988 онд өндөр насны тэтгэвэрт гарч 1992 оны наймдугаар сарын 21-нд таалал төгсчээ.

Адилбиш гуай ноогдуулсан албан үүргийг биелүүлэхдээ ямагт "Монгол эх орныхоо төлөө" гэсэн халуун сэтгэлээр өөрийн мэдлэг, хүч чадал, ажлын арвин баялаг туршлагаа дайчлан зүтгэж байсан тул ажил нь өөдрөг, өмнөө тавьсан зорилгоо нэр төртэй биелүүлж байсан юм. Түүнийг ойн баврын дурсгалын медалиас эхлээд Сүхбаатарын одон, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Ош бөгөөд Бүрэн эрхт элчин сайд цолоор шагнажээ.

Адилбиш гуай төрөлхийн уужуу сайхан ухаантай, олон улсын болон өөрийн орны байдал, төлөвийг маш нарийн ухаарч, ажилтайгаа холбогдсон зүйлийг тал бүрээс нь нямбай судалж, амьдрал ямар чигт явж байгааг дүгнэн цэгнэж, түүнтэй уралдан ажилладаг төрийн том

ЭНЭТЭГЭН байлаа. Түүнийг 1956 онд ГЯН-ны сайдаар томилсон үе бол манай гадаад харилцаа хязгаарлагдмал хүрээнд өргөжих төлөвтэй байсан боловч нэг хэт их гүрний эрхшээлд хэтэрхий орсон, дотооддоо эргэцлөх, бусдыг хуулах компани ид хүчээ авч байсан үе юм. Адилбиш гуай тэр үед өөрийн орны гадаад харилцааг харилцан адил тэгш байх үндсэн дээр орон бүхэнтэй элдэв ялгаваргүй хөгжүүлэхийг чармайж байсан юм. Үндэсний хэл бичиг, соёлоо эрхэмлэн хөгжүүлэхийг анхаарч, ялангуяа монгол хэл бичгээ гадаад харилцааны болон өдөр тутмын ажилд оновчтой хэрэглэхийг эрмэлздэг байсан юм. Тэр үед албан ёсны цуглаан дээр Адилбиш гуай "бид ус зөөдөг машин дээрээ вода, талх зөөдөг тэргэн дээрээ хлеб гэж бичдэгээ болгимоор биднэ" гэсний төлөө "Ленин-Сталины хэлийг хэрэглэхэд юу нь буруу байна" гэсэн зэмлэлийг дээрээс хүртэж байв. Тавиад оны дунд, түүнчлэн сэхээтний тухай яриа идэвхжиж байхад манай удирдагчид "Түмэг өөгшүүлэн" ...хэлэх ярих юмаа бид нарт чөлөөтэй ярь" гээд нь дээд сургууль, албан газруудад сэхээтний яриг сонсох хүмүүсийг тэмдэглэн явуулж, байдаг бүгдийг нь хэлүүлж аваад эцэст нь тогтоол гаргаж "сэхээтний төөрөгдөл" гэгчийг буй болгож тааламжгүй хүмүүсээ өгсгөлдүүлж эхлэхэд Адилбиш гуай "Энэ хэл яриа гаргаж байгаа сэхээтнүүд бол нам, засаг, ард түмэндээ буруу санасандаа биш, тус орноо түргэн хугацаанд сайн сайхан болгохсон гэсэндээ чин сэтгэлзсээ ярьж байгаа хүмүүс" гэж сэхээтнээ тууштай хамгаалж байлаа. Д.Адилбиш аливаа асуудалд тэвчээртэй, буйр суурьтай аргачлал хамт бусдад бууж өгөхгүй, долгинохгүй, хэлэх гэсэн юмаа сонд ч хаана ч зоригтой хэлж чаддаг нь түүний сэтгэхүй, ухааны дүрсэл байсан юм.

Гадаад харилцаа хязгаартай хөгжих үе эхэлж байсан тэр цагт монголчуудын тулширдаг зуршил мөн л хүчтэй илэрч олон улсын харилцааг хэвшин явагдаж ирсэн харилцааны хэм хэмжээг үл хайхрах юм үү, айл зэргэлдээ нэг гүрний нэг үндэстэн шиг байхыг хичээх, бид гадаад бодлогоо нэг загварт, нэг үзэл санаанд захируулахыг эргэлдэж, өөрийн онцлог, өөрийн хөгжлийн хэмжээ, хүн амын тоо, газар зүйн байршил энэ бүгдийг үл хайхрах явдал засаг төрийн дээд зорилго, яам, газрын удирдагчдын түвшинд тод илэрч байсан юм. Харин Адилбиш гуай бол өөрөөр хандаж, өөрийн гэсэн гадаад бодлого баримтлан ажиллахыг хичээж байлаа.

ГЯН-ны сайдын хувиар гадаад бодлогыг хэрэгжүүлэхдээ аль болох олон сайн түнш улстай, дайсанлагч улсгүй байхыг хичээж байв. Энэ бол үнэндээ зөвсэлд үл нэгдэх чиг шугам байсан юм. Мөн социалист лагерь гэж байхад түүнд багтаж байсан орон бүхэнтэй адил